

## Хараат бус аудиторын тайлан

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн УДИРДЛАГА БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

### Зөрчилгүй санал дүгнэлт

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн (цаашид компани гэх) 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь Компанийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлагаа хэсэгт харуулсан. Бид Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хуулийн эдгээр шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж бид найдаж байна.

### Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан, бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь Компанийн үйл ажиллагааг зогсох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл үнээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах компанийн чадамжийг үнэлж, бопомжтой бол тасралтгүй байх зарчимтай холбогтой асуудлуулыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайллагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Аудиторын зорилго нь санхүүгийн тайлангууд бүхэлдээ залилан юмуу алдаанаас үүдэлтэй, материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад оршино. Ул үндэслэлтэй баталгаа нь б аталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба тэр нь материаллаг болж, эдгээр алдаа нь санхүүгийн тайлангууд

дээр суурилан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэл болж болзошгүй гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмжээ ашиглаж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримталсан болно. Мөн түүнчлэн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоо явдлууд багтсан байж болно.
- Аудитын горимуудыг сонгохтой холбоотойгоор дотоод хяналтуудыг судалдаг ба энэ нь Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоололын ул үндэслэл болон удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл Аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртлэх олж авсан Аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруултыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцдаг.

Санхүүгийн тайлангийн аудитын үед аудиторын хүлээх үүрэг хариуцлагын талаарх мэдээллийг ММНБИ-ийн [monicra.mn](http://monicra.mn) сайтад байрлах манай аудитын компанийн холбоосонд байрлуулсан бөгөөд энэхүү дэлгэрэнгүй мэдээлэл нь бидний аудиторын тайлангийн хэсэг болно.

#### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг МУ-ын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох "ХӨСӨГ ТРЕЙД" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг туравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Д.ТОВУУДОРЖ